



“ТАВАН ТОЛГОЙ ТУЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/185

Улаанбаатар хот

Зааварчилгаа батлах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, “Таван толгой түлш” ХХК-ийн дүрмийн 7.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сайн карт”-ыг үрэгдүүлж, гээгдүүлсэн тохиолдолд картыг шинэчлэн захиалах зааварчилгааг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааварчилгааг ард иргэдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Борлуулалтын хэлтэс /Д.Миняа /-т даалгасугай.
3. Зааварчилгааны дагуу ард иргэдэд түргэн шуурхай үйлчилж ажиллахыг мэдээлэл технологийн инженер /Б.Даваадорж/, Мэдээллийн төв /Ж.Чулуун/-д тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын алба /Р.Гансүх/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ГАНБААТАР

"Таван толгой түлш" ХХК-ийн Гүйцэтгэх
захирлын 2019 оны 11 сарын 00 өдрийн
А/165 дугаар тушаалын хавсралт

ҮҮРЭГДҮҮЛЖ, ГЭЭГДҮҮЛСЭН КАРТЫГ ШИНЭЧЛЭН ЗАХИАЛАХ ЗААВАРЧИЛГАА

1. Хэрэглэгч ТА картаа үрэгдүүлж, гээгдүүлсэн тохиолдолд Хэрэглэгчийн төв /70119400/-
д хандаж картаа хаалгана.
2. Чингис хаан банкны 3401004344 тоот дансанд шинэ картын төлбөр болох 3000 /гурван
мянган/ төгрөг шилжүүлнэ. /хүлээн авагчийн нэр дээр ТТТ картын хураамж, шилжүүлгийн утга
у овог, нэр, регистрийн дугаар бичнэ/.
3. "Таван толгой түлш" ХХК-ийн төв оффис /Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 8, "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн Б байр 121 тоот/-т
байрлах "Мэдээллийн төв"-ийн ажилтанд мөнгө тушаасан банкны баримтыг үзүүлж, шинэ карт
авах захиалга хийнэ.
4. Шинэ картыг захиалсан өдрөөс 3 хоногийн дараа Даваа, Лхагва, Баасан гарагт "Таван
толгой түлш" ХХК-ийн төв оффисоос авна.